



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№79 /523/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.05.17

Цаг үе, үйл явдал

ГОВИЙН БҮСЭД ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖИЙН ХЭЭРИЙН ДАДЛАГА ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Монгол Улсын Засгийн газар, Батлан хамгаалахын сайдын шийдвэрээр орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хэрийн дадлага сургууль 2023 оны 5 дугаар сарын 12-16-ны өдөр Өмнөговь аймагт амжилттай болж өндөрлөлөө. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Батлан хамгаалахын сайд, Өмнөговь аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний дагуу энэхүү дадлага сургуулийг тус аймгийн 15 сумын иргэдээс томилгоот нэгжийн төлөөлөл, удирдах бүрэлдэхүүнийг болзошгүй цагийн байдалд орон нутгаа хэрхэн хамгаалах, шаардлагатай үед эзэмшвэл зохих ур чадварт сургах зорилгоор зохион байгуулсан

Засаг дарга Р.Сэддорж, Батлан хамгаалахын сайдын зөвлөх Ц.Дашзэвэг, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ХЗЦК-ын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр тус аймгийн Засаг даргын орлогч Н.Энхбат болон бусад албаныхан оролцлоо.

Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2018 онд Монгол Улсын Их Хурлаар Орон нутгийн хамгаалалтын тухай анхдагч хуулийг батлуулсан нь орон нутгаа хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, түүний бэлтгэлийг хангах талаарх төр, засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, хуулийн этгээд, улмаар иргэний хүлээх үүргийг зохицуулснаараа ихээхэн ач холбогдолтой баримт

бөгөөд энэ удаагийн сургалт стратегийн чухал чиглэлд байрлах тус аймагт зохион байгуулагдлаа. Сургалтын явцаас харахад богинохон хугацаанд томилгоот иргэд маань гүйцэтгэх үүрэгтээ хэрхэн суралцсаныг харлаа. Монгол хүн бүрийн сэтгэл зүрхэнд эх орноо хайрлах сэтгэл дүүрэн байдаг нь ч энэхүү сургалтаас



харагдаж байна. Дадлага сургалтыг явуулсан аймаг, сумдын удирдлага, идэвхтэй оролцсон иргэдэд, хуульд заасан үүргээ биелүүлэн дэмжлэг үзүүлэн ажилласан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад талархал илэрхийлье” гэлээ.

Мөн Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Сэддорж Цэргийн штабын зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагаа, сургалт бэлтгэл, Орон нутгийн хамгаалалтын нөөцийн бүрдүүлэлт болон тус нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулдаг Зэвсэгт хүчний анги, салбаруудад хуулиар хүлээсэн үндсэн болон бусад үүргээ гүйцэтгэхэд нь тал бүрээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байгааг хэллээ.



Үргэлжлүүлэн “Хэрийн дадлага сургалтад оролцсон 15 сумын төлөөлөл нь онц болон гамшиг ослын үед орон нутаг, ард иргэдээ хэрхэн хамгаалан ажиллах талаар их зүйлийг сурч мэдсэн төдийгүй цаашид түүнийгээ бусадтайгаа хуваалцаж, сум орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад удирдан, манлайлж ажиллана гэдэгт итгэлтэй байна. Өмнөговь аймгийн

бэлтгэл үүрэгтнүүдэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, сургагч багш нарт талархал илэрхийлье. Цаашид ч орон нутгийн удирдлагын хувьд хуулийн этгээдүүдийг орон нутгийн хамгаалалтын үед гүйцэтгэх үүрэгт нь бэлтгэх ажлыг хариуцан зохион байгуулахын зэрэгцээ БХЯ, ЗХЖШ, өөрийн орон нутаг дахь Зэвсэгт хүчний байгууллагуудтай улс орноо батлан хамгаалах нэгдмэл үйлсээрээ харилцан уялдаатай ажилласаар байх болно” гэсэн юм.



Сургалтын төгсгөлд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, аймгийн удирдлагууд Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хэрийн дадлага, сургалтад амжилттай оролцсон сумын удирдлага, томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, идэвх оролцоогоороо тэргүүлсэн иргэдийг шагнаж урамшуулсан юм.



ЗХЖШ-аас томилогдсон сургалтын бүлэг удирдан явуулсан тус сургуулиар бодит цагийн байдал үүсгэн, томилгоот бүрэлдэхүүн тухайн газар оронд техник, галт зэвсэг, агт морьд, атан тэмээ, орчин үеийн дэвшилтэт технологи дрон зэргийг ашигласнаараа онцлог байв.

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хэрийн дадлага сургуулийн хаалтын ажиллагаанд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Өмнөговь аймгийн

бичиг болсон гэдгийг Батлан хамгаалахын сайд эхэнд нь онцлов.

Тэрээр “Манай улсын хувьд өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөн, геостратегийн байршил, эдийн засгийн чадавч, боломж зэргээс шалтгаалан төрийн бүх шатны байгууллагын хамтын ажиллагаа, нийт иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалтыг хөгжүүлж, бэхжүүлэх нь улс орноо батлан хамгаалах хамгийн оновчтой тогтолцоо гэж үзэж байна. Энэхүү хэрийн дадлага сургалтыг өнгөрсөн онд анх удаа Өвөрхангай аймагт бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8	-1


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,456	3,466
EUR	3,770	3,789
CNY	499	501
RUB	42,90	43.50
JPY	26	27,10
KRW	2.61	2.62

ЗУРХАЙ



2023.05.17 /ЛХАГВА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 28

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.13-20.24

Барилдлага:

Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Төрөн түгэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 688,380,034

Эдгэрсэн

Нийт: 660,813,815

Нас барсан

Нийт: 6,875,571

Цахим шууданд

ОУХМ АХЛАХ АХЛАГЧ Б.ЧИНЗОРИГИЙГ АЛДАР СПОРТ ХОРООНЫ УДИРДЛАГУУД ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Э.Бадар-Ууган, Н.Төгсцогт, Л.Алтанцэцэг нар дэлхийд үзүүлж байсан билээ.

ОУХМ ахлах ахлагч Б.Чинзориг: 2005 онд Алдар спорт хороонд А.Гантулга багшийн шавь болж үүнээс хойш 18 дах жилдээ боксын спортоор хичээллэж байна. Дөрвөн ДАШТ, хоёр олимпид оролцсон. Үүнээс гуравт нь медалийн төлөө тоглож энэ удаа мөнгөн медаль хүртлээ. Миний хувьд Батлан хамгаалах яамны харьяа Алдар спорт хороо гэх энэ их өрх айлд багтаж олон ч жил "гэр хийж" явлаа. Намайг цаг үргэлж дэмжиж, дэлхийн тэмцээнд захыг минь мушгин суудаг эл хамт олонд талархахгүй байхын аргагүй. Та бүгддээ чин сэтгэлийн талархал илэрхийлье" гэлээ.



Узбекистан Улсад ахлах ахлагч Б.Чинзоригийг болсон "Ташкент-2023" боксын өнөөдөр Алдар спорт хорооны эрэгтэйчүүдийн насанд удирдлагууд хүлээн авч хүрэгчдийн ДАШТ-ний 63.5 кг жинд Монгол Улсаа төлөөлөн оролцсон үндэсний шигшээ багийн ахлагч, Алдар спорт хорооны тамирчин, ОУХМ

Тэрбээр ДАШТ-ээс мөнгөн медаль хүртсэн Монголын зургаа дахь боксчин болсон юм. Өмнө нь Р.Отгонбаяр, Т.Үйтүмэн,

САНХҮҮЧДИЙН СУРГАЛТААР ...



Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалууд, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, салбаруудын санхүүгийн дарга, ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч нартай мэргэжил, арга зүйн сургалтыг энэ сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж байна.

Сургалтыг "Зэвсэгт хүчний санхүүгийн үйл ажиллагаанд хууль, дүрэм, журмын хэрэгжилт, тулгамдсан асуудал, гарсан алдаа зөрчил, арилгах арга зам" сэдвийн хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой Монгол Улсын хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам, зааврыг Зэвсэгт хүчний санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд санхүү, бүртгэлийн ажилтнуудын үүрэг, оролцоо, мэргэжлийн ур чадварыг

дэвшлүүлэх, аудит болон бусад санхүүгийн шалгалтаар зөрчил гаргахаас сэргийлэх, гарсан алдаа, зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх зорилгоор явагдаж байна. Хөдөө орон нутаг дахь Зэвсэгт хүчний анги, салбаруудын албан тушаалтнууд цахимаар оролцож байна.

Мэргэжил, арга зүйн сургалтыг ЗХЖШ-ын санхүүгийн хэлтсийн дарга хурандаа Б.Бүрэнтөгс нээж үг хэлж, Төрийн худалдан авах ажиллагааны газрын сургалт хариуцсан мэргэжилтэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Татварын улсын байцаагч, БЗД-ийн НДХ-ийн тэтгэврийн хяналтын байцаагч нар тус тус урилгаар ирж сургалт явууллаа.

Хошууч Э.ГАНБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИ "МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР"-Т НЭГДЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, ЗХЖШ-ын даргаар батлуулсан "Агропарк" байгуулах төлөвлөгөөний дагуу ангийн байрлалд ногоон хотхон бий болгох, мод үржүүлгийн газар байгуулах ажлыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний 340 дүгээр анги "Мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан ангийн байрлалд мод тарих тусгай төлөвлөгөө гарган 5 сарын 11-ний өдрөөс эхлэн хоёр өдрийн турш 4 төрлийн улиас, хальс, шар хуайс, бургасны тарьцыг суулгалаа.

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙНХЭН "АХЛАГЧ", "САПЕРЧИН" ТӨГӨЛ БАЙГУУЛНА



Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийнхан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас хэрэгжүүлж байгаа "Эко-Ногоон хотхон" төслийн хүрээнд ангийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ажиллах орчныг ая тухтай болгох хүрээнд шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа билээ.

2022 онд орчны ногоон байгууламжийг сэргээн сайжруулж цэцэрлэгжүүлэх, мод, бут, зүлэг тарих, түүнийг хамгаалах хашаа татах, усалгааны систем хийж, ангийн гаднах болон дотоод эко орчныг нэмэгдүүлэх, тохижуулахад ихээхэн анхаарч ажилласан бөгөөд БХЯ, ЗХЖШ, ХЗЦК-ын удирдлагуудаас "Үлгэр жишээ ногоон байгууламжтай анги" хэмээн талархал дэвшүүлсэн юм.

Инженерийн цэргийнхэн 2022 оны амжилтаа бататгахаар энэ жил ангийн байрлалд "Ахлагч", гадна талбайд "Саперчин" төглийг тус тус

байгуулж гацуур, нарс, монос, агч, хайлаас, улиас зэрэг 14 нэр төрлийн 7000 гаруй мод, бут, суулгацыг тарьж байна. Мод тарихын зэрэгцээ иргэдийн нүдэнд ил тод гадна орчиндоо цэцгийн мандал байгуулах, гэрэлтүүлэг, явган хүний зам, усалгааны иж бүрэн систем байгуулах, шалган нэвтрүүлэх байрны өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зэрэг тохижилтын ажлыг гүйцэтгэж байгаа юм.

Түүнчлэн ногоон байгууламжаа мэргэжлийн түвшинд байгуулах, арчлан тордохын тулд газар тариалангийн "Сэрүүн Дунбарай" компанийн сургалтад хоёр ахлагчийг 21 хоногийн хугацаатайгаар бэлтгүүлэв. Бэлтгэгдсэн экологичид ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, ажлын орчин болон хувийн орон сууцныхаа эргэн тойрныг хэрхэн эрүүл мэндэд ээлтэй ая тухтай болгох, ногоон байгууламжаа нэмэгдүүлэхэд юунд анхаарах талаар мэдээлэл өгсөн юм.

Хошууч Э.ХАШЦАХИУР

"У-ШУ САНДА" БОКСЫН УАШТ-НД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 150 ДУГААР АНГИЙН ТАМИРЧИД ӨНГӨЛЛӨӨ



2023 оны "У-ШУ САНДА" боксын УАШТ-нд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тамирчид амжилттай оролцлоо. Тус тэмцээнд 26 багын 180 гаруй тамирчид өрсөлдсөнөөс 56 кг жинд ахлагч Г.Мөнхбат мөнгө, 60 кг жинд ахлагч Б.Галсанравжих алт, 65 жинд Ахмад С.Сүхболд алт, 70кг жинд ахлагч О.Ууганбаяр хүрэл, -75кг жинд ахлах түрүүч Б.Очирхуяг мөнгө медалийг тус тус хүртэж Зэвсэгт хүчний 150 дугаар анги багийн дүнгээр хоёрдугаар байрыг эзэллээ. Ташрамд дуулгахад ахмад С.Сүхболд энэ удаагийн УАШТ-нд ахин түрүүлснээр УАШТ-ний медалийн тоогоо нэгээр нэмж 9 удаагийн үнэмлэхүй аварга болсон юм.

"НЭГ ГЭР БҮЛ-НЭГ МОД"



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд Зэвсэгт хүчний 150 дугаар анги "Нэг гэр бүл-Нэг мод" аяныг зохион байгуулав. Аянаар бургас модны 730 ширхэг суулгацыг "Хүй долоон худаг"-ийн районд ажилтан, цэргийн алба хаагч нар гэр бүлийн гишүүдийн хамтаар тарьж цэвэр агаарт цагийг үр бүтээлтэйгээр өнгөрүүлсэн юм.

